



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/6661

Мандалговь

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд
бэлэг гардуулах тухай

Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 9 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн хөгжлийн бэрхшээлтэй зарим хүүхдэд бэлэг гардуулсугай.

Хоёр. Нэг хүүхдийн бэлгийг 15000 төгрөгөөр тооцож хүүхдийн бэлэгт зарцуулагдах 90000 (Ерэн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200769